ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/100/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Аудитор Б.Нямдорж<br>Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ..... 1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 3
3. Аудитын тайлан ..... 11
3.1 Ерөнхий зүйл ..... 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12
3.4 Материаллаг байдал ..... 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 14
3.8 Аудитын гол асуудал ..... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14.
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 14
4. Аудитын илрүүлэлт ..... 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 16

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 138

танай ________ -ны № ________ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦЭЭЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.БАТБАЯР ТАНАА

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020265

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | **51,656,415.27** | **48,794,133.50** |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | **51,656,415.27** | **48,794,133.50** |
| **35100** | **Түүхий эд материал** | **6,673,404.00** | **8,510,077.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,673,404.00 | 8,225,797.00 |
| 35130 | Эм боох материал | - | 284,280.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **44,883,011.27** | **40,184,056.50** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 499,000.00 | 368,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 33,248,097.00 | 34,508,032.39 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,517,864.81 | 3,005,700.81 |
| 35460 | Хүнсний материал | 1,482,649.46 | 1,166,923.30 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,135,400.00 | 1,135,400.00 |
| 35600 | Мал амьтад | 100,000.00 | 100,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | **581,703,730.28** | **693,753,744.48** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | **581,703,730.28** | **693,753,744.48** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **539,461,730.28** | **651,511,744.48** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 530,140,672.07 | 530,140,672.07 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (78,220,743.94) | (89,044,510.62) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 20,600,000.00 | - |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (20,600,000.00) | - |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 232,426,958.20 | 169,230,713.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (216,489,488.98) | (42,042,450.37) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 77,158,423.00 | 84,606,769.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,049,237.26) | (27,814,048.91) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 31,200,263.00 | 19,685,200.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (23,368,749.41) | (6,671,236.41) |
| 39217 | Ном | 11,663,633.60 | 13,420,636.72 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **42,242,000.00** | **42,242,000.00** |
| 39301 | Програм хангамж | 480,000.00 | 480,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (480,000.00) | (480,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 42,242,000.00 | 42,242,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | **633,360,145.55** | **742,547,877.98** |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | **633,360,145.55** | **742,547,877.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **633,360,145.55** | **742,547,877.98** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 442,565,295.60 | 442,565,295.60 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(119,858,011.99)** | **(10,670,279.56)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (84,862,129.40) | (119,858,011.99) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (34,995,882.59) | 109,187,732.43 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 310,652,861.94 | 310,652,861.94 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | **633,360,145.55** | **742,547,877.98** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **845,723,939.50** | **978,155,179.01** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **37,193,351.50** | **143,080,823.01** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **37,193,351.50** | **143,080,823.01** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 37,193,351.50 | 143,080,823.01 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **808,530,588.00** | **835,074,356.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **744,539,000.00** | **774,822,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 744,539,000.00 | 774,822,000.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **19,185,388.00** | **12,446,156.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 5,624,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,791,288.00 | 4,566,356.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,394,100.00 | 2,255,800.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **44,806,200.00** | **47,806,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 44,806,200.00 | 47,806,200.00 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **880,648,072.13** | **868,967,446.58** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **880,648,072.13** | **868,967,446.58** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **816,813,989.88** | **817,247,538.70** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **586,059,774.63** | **613,140,226.22** |
| 210101 | Үндсэн цалин | 495,726,909.73 | 518,776,012.02 |
| 210104 | Урамшуулал | 44,193,382.90 | 47,168,214.20 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 46,139,482.00 | 47,196,000.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **79,559,719.46** | **85,910,678.83** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,552,719.46 | 63,267,656.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,080,000.00 | 5,534,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,047,200.00 | 4,711,022.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,261,800.00 | 1,127,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,618,000.00 | 11,271,000.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **42,632,807.66** | **49,985,515.08** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,265,111.66 | 5,663,351.08 |
| 210302 | Түлш, халаалт | 38,167,696.00 | 43,312,164.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,200,000.00 | 1,010,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **36,545,319.41** | **6,569,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,014,400.00 | 1,941,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,959,500.00 | 2,929,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 966,600.00 | 598,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 348,500.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,005,000.00 | 1,100,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 24,251,319.41 | - |
| 2105 | **Нормативт зардал** | **19,612,083.08** | **17,458,418.15** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 600,000.00 | 796,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,612,083.08 | 15,892,018.15 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,400,000.00 | 770,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,720,000.00** | **7,300,000.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 720,000.00 | 720,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 6,580,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **588,400.00** | **456,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 588,400.00 | 456,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,190,100.00** | **2,985,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,394,100.00 | 2,985,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | - |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **45,905,785.64** | **33,442,200.42** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,569,700.00 | 2,268,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 44,336,085.64 | 31,173,700.42 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 63,834,082.25 | 51,719,907.88 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **33,524,188.00** | **23,549,886.01** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,732,900.00 | 20,713,498.01 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,791,288.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,000,000.00 | 2,836,388.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,505,088.34** | **1,332,848.92** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,505,088.34 | 1,332,848.92 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **28,804,805.91** | **26,837,172.95** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,804,805.91 | 26,837,172.95 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(34,924,132.63)** | **109,187,732.43** |
| IV | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| V | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **71,749.96** | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 71,749.96 | - |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(34,995,882.59)** | **109,187,732.43** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 442,565,295.60 | 310,652,861.94 | (84,862,129.40) | 668,356,028.14 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 442,565,295.60 | 310,652,861.94 | (84,862,129.40) | 668,356,028.14 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| 8 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | (34,995,882.59) | (34,995,882.59) |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 442,565,295.60 | 310,652,861.94 | (119,858,011.99) | 633,360,145.55 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 442,565,295.60 | 310,652,861.94 | (119,858,011.99) | 633,360,145.55 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 442,565,295.60 | 310,652,861.94 | (119,858,011.99) | 633,360,145.55 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 109,187,732.43 | 109,187,732.43 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 442,565,295.60 | 310,652,861.94 | (10,670,279.56) | 742,547,877.98 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **809,530,588.00** | **835,074,356.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **809,530,588.00** | **835,074,356.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **744,539,000.00** | **774,822,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 744,539,000.00 | 774,822,000.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **20,185,388.00** | **12,446,156.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 0 | 5,624,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,791,288.00 | 4,566,356.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,394,100.00 | 2,255,800.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **44,806,200.00** | **47,806,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 44,806,200.00 | 47,806,200.00 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **809,530,588.00** | **835,074,356.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **809,530,588.00** | **835,074,356.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **745,696,505.75** | **783,265,446.13** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **586,059,774.63** | **613,140,226.22** |
| 210101 | Үндсэн цалин | 495,726,909.73 | 518,776,012.02 |
| 210104 | Урамшуулал | 44,193,382.90 | 47,168,214.20 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 46,139,482.00 | 47,196,000.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **79,559,719.46** | **85,910,678.83** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,552,719.46 | 63,267,656.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,080,000.00 | 5,534,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,047,200.00 | 4,711,022.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,261,800.00 | 1,127,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,618,000.00 | 11,271,000.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 0 | 0 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **41,301,111.66** | **44,473,351.08** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,265,111.66 | 5,663,351.08 |
| 210302 | Түлш, халаалт | 36,836,000.00 | 37,800,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,200,000.00 | 1,010,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **12,687,900.00** | **7,272,500.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,208,300.00 | 1,920,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,959,500.00 | 2,905,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 966,600.00 | 598,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 700,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 348,500.00 | 48,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,005,000.00 | 1,100,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **17,714,700.00** | **16,743,190.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 600,000.00 | 485,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,714,700.00 | 15,487,290.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,400,000.00 | 770,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,720,000.00** | **10,005,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 2,705,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 720,000.00 | 720,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 6,580,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **588,400.00** | **456,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 588,400.00 | 456,000.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,190,100.00** | **2,985,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,394,100.00 | 2,985,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | 0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,874,800.00** | **2,279,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,874,800.00 | 2,279,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **63,834,082.25** | **51,808,909.87** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **33,524,188.00** | **23,638,888.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,732,900.00 | 20,802,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,000,000.00 | 2,836,388.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,505,088.34** | **1,332,848.92** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,505,088.34 | 1,332,848.92 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **28,804,805.91** | **26,837,172.95** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,804,805.91 | 26,837,172.95 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0 | 0 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **822,628,200.00** | **794,458,534.13** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **822,628,200.00** | **794,458,534.13** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **796,525,600.00** | **770,819,646.13** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **614,263,400.00** | **613,140,226.22** |
| 210101 | Үндсэн цалин | 523,949,400.00 | 518,776,012.02 |
| 210104 | Урамшуулал | 43,118,000.00 | 47,168,214.20 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 47,196,000.00 | 47,196,000.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **106,937,000.00** | **85,910,678.83** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,395,000.00 | 63,267,656.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,534,000.00 | 5,534,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,610,000.00 | 4,711,022.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,127,000.00 | 1,127,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,271,000.00 | 11,271,000.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **45,806,200.00** | **44,473,351.08** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,800,000.00 | 5,663,351.08 |
| 210302 | Түлш, халаалт | 37,806,200.00 | 37,800,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,200,000.00 | 1,010,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **5,920,600.00** | **5,841,500.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,033,500.00 | 1,029,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,691,700.00 | 2,665,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 600,000.00 | 598,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 400,000.00 | 400,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 95,400.00 | 48,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **18,338,400.00** | **16,743,190.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 575,000.00 | 485,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,993,400.00 | 15,487,290.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 770,000.00 | 770,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,720,000.00** | **2,720,000.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 720,000.00 | 720,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **700,000.00** | **456,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 700,000.00 | 456,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **490,000.00** | **429,700.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 490,000.00 | 429,700.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,350,000.00** | **1,105,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,350,000.00 | 1,105,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,102,600.00** | **23,638,888.00** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **26,102,600.00** | **23,638,888.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,802,600.00 | 20,802,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,300,000.00 | 2,836,388.00 |
| III | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **822,628,200.00** | **794,458,534.13** |
| 31 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **774,822,000.00** | **747,985,183.05** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 774,822,000.00 | 747,985,183.05 |
| 32 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **47,806,200.00** | **46,473,351.08** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 47,806,200.00 | 46,473,351.08 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,446,156.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,446,156.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 12,445,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,431,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 891,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 240,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,285,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,705,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,580,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,555,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,555,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,174,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,174,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **356.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 356.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **12,446,156.00** |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | **12,446,156.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,624,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,566,356.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,255,800.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг "Шилэн баланс аудит" ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 759.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 12.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны нийт зардал 868.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14.6 хувиар буюу 108.4 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48.7 сая төгрөг болж 2.9 сая төгрөгөөр буурсан нь хангамжийн материал буурсантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 90.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 95.9 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 693.7 сая төгрөг болж 112.0 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө шилжүүлэн авсантай. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2.3 сая төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 3.8 сая төгрөгийн хөрөнгө, 15.9 сая төгрөгийн хөрөнгө, 121.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 741.7 сая төгрөг болж 108.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 6.0 хувиар буюу 47.6 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 741.7 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 921.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 99.0 сая төгрөгөөр бууруулан, 822.6 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 822.6 сая төгрөгийн төсөв батлснаас 774.8 сая төгрөгийг улсын төсвөөс 47.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 774.8 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 47.8 сая төгрөг нийт 822.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 794.5 сая төгрөгийг зарцуулж 26.8 сая төгрөгийг улсын төсөвт, 1.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 794.5 сая төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 1.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 20.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.2 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг 2.5 сая төгрөгөөр, эмийн зардлыг 0.08 төгрөгөөр, хоолны зардлыг 1.5 сая төгрөгөөр, бусад зардлыг 0.8 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчаас 4.5 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2.2 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 5.6 сая төгрөг нийт 12.4 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Үүнээс эд хогшил урсгал засварын зардалд 7.2 сая төгрөг, бараа үйлчилгээний зардал 1.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

зардлыг 2.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 1.7 сая төгрөг, зарцуулж 365 төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайлангийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 40 мэдээллээс 14 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба мэдээлээгүй 24, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан тухай албан бичиг ирүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар:

- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа эсэхийг шалгах

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бараа материалын тайлангийн тулгалт,

- Хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг ажлын даалгаврын дагуу бэлтгэсэн, хөрөнгийн чанар, хугацаандаа нийлүүлсэн эсэх
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 0.7 сая төгрөгийн зөрчлийг залруулж,11.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй хүлээн авсан 0.7 сая төгрөгийн материалыг бараа материалын дансанд бүртгэж, залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитын явцад төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага

- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дунд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан орон тооноос багшийн 3 орон тоо илүү ажиллаж 11.1 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Боловсрол соёл урлагийн газрын даргын 2021 оны 10 сарын 14-ны 258 дугаар тушаалтай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Хөдөлмөрийн чадвараар алдсаны тэтгэмж болох 0.4 сая төгрөгийг татварын тайлангийн ТТ-11-д тусгаж тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Албан татвараас чөлөөлөх орлого” 22.1.1-т “.хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж” гэж заасантай нийцэхгүй тул албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангуулах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 1. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 40 мэдээллээс 14 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба мэдээлэлгүй 24, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. 2021 оны 424.9 сая төгрөгийн 40 мэдээллийг ил тод байршуулахаас 183.5 сая төгрөгийн 16 мэдээллийг байршуулж 232.8 сая төгрөгийн 24 мэдээлэл байршуулаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Цээл сумын ерөнхий боловсролын сургууль | 5 | 12.3 | 1 | 0.7 | 0 | 0 | 3 | 11.6 | 1 | - |
| | **НИЙТ ДҮН** | **5** | **12.3** | **1** | **0.7** | **0** | **0** | **3** | **11.6** | **1** | **-** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР